

Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 06 дугаар
сарын 11-ний өдрийн 225 дугаар тогтоолоор баталсан
“Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 4 дүгээр хавсралт

Жилийн үйл ажиллагааны тайлагнал /маягт 1/				
Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.				
Тайлагнах хугацаа	2025 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр			
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	Нэр: АПУ ХУВЬЦААТ КОМПАНИ УБГД: 000165753, РД: 2702673 ҮЦКод: АПУ /90/ Утас: 11-344336, 76002220			
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Монголын хөрөнгийн бирж			
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Шингэн хүнсний үйлдвэрлэл			
Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргасан СЗХ-нд бүртгэлтэй аудитын компанийн нэр, бүртгүүлсэн огноо	“Прайсуотерхаускуперс Аудит” ХХК 2012 оны 08 дугаар сарын 08-ны өдөр			
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	1,064,181,553			
Жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Санхүү, тайлагналын албаны тайлагналын менежер Н.Мягмардорж, ТУЗ-ийн ажлын албаны комплайнсын мэргэжилтэн Б.Мягмар, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Сарантунгалаг			
1.	Тайлант жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/			
Санхүүгийн байдлын үзүүлэлт	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Дахин тайлагнасан эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
	Хөрөнгө			
	Эргэлтийн хөрөнгө	459,562,588,000	391,983,751,000	414,667,854,000
	Эргэлтийн бус хөрөнгө	618,993,441,000	590,086,592,000	717,682,914,000
	Нийт хөрөнгө	1,078,556,029,000	982,070,343,000	1,132,350,768,000
	Өр төлбөр ба эздийн өмч			
	Богино хугацаат өр төлбөр	149,687,247,504	107,752,461,000	93,098,212,000
	Урт хугацаат өр төлбөр	133,869,189,000	102,287,141,000	196,960,535,000
	Эздийн өмч	794,999,592,496	772,030,741,000	842,292,021,000
	Нийт өр төлбөр ба эздийн өмч	1,078,556,029,000	982,070,343,000	1,132,350,768,000
Орлогын тайлан	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Дахин тайлагнасан эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
	Борлуулалтын орлого (цэвэр)	1,327,522,591,000	1,340,375,302,000	1,320,663,900,000
	Борлуулалтын өртөг	(680,502,489,000)	(774,356,838,000)	(748,938,545,000)
	Нийт ашиг (алдагдал)	647,020,102,000	566,018,464,000	571,725,355,000
	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	241,518,700,000	284,841,792,422	253,974,906,433
	Орлогын татварын зардал	(48,627,848,000)	(65,094,427,000)	(46,117,497,000)
	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	192,890,852,000	219,747,365,422	207,857,409,433
	Бусад дэлгэрэнгүй орлого	(574,399,000)	(574,399,000)	747,472,000
	Нийт орлогын дүн	192,316,453,000	219,172,966,422	208,604,881,433
	Толгой компанийн хувьцаа эзэмшигчэд ноогдох	221,899,869,000	219,172,966,422	208,604,881,433
	Хяналтын эрхгүй хувь оролцоонд ноогдох	(29,583,416,000)	-	-

	Өмчийн өөрчлөлтийн тайлан	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Дахин тайлагнасан эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
		Өмч	106,418,200	106,418,200	106,418,200
		Халаасны хувьцаа	-	-	-
		Нэмж төлөгдсөн капитал	226,646,951,296	226,646,951,800	226,646,951,800
		Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэг	156,572,931,000	156,572,931,000	155,109,751,000
		Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	(457,461,000)	(457,461,000)	745,860,000
		Хуримтлагдсан ашиг	392,482,641,000	389,161,901,000	459,683,040,000
		Нийт эздийн өмчийн дүн	775,351,480,496	772,030,741,000	842,292,021,000
		Хяналтын бус хувь оролцоо	19,648,112,000	-	-
		Нийт дүн	794,999,592,496	772,030,741,000	842,292,021,000
	Мөнгөн гүйлгээний тайлан	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Дахин тайлагнасан эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
		Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	264,058,000,000	288,244,042,512	272,298,611,109
		Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	124,392,028,000	(116,964,266,503)	(196,018,554,512)
		Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(168,266,199,000)	(180,085,733,000)	(46,146,672,013)
		Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(28,600,227,000)	(8,805,956,992)	30,133,384,584
		Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	122,152,090,000	87,916,831,000	78,539,186,008
		Мөнгөн хөрөнгийн үнэ цэнийн бууралт болон валютын ханшийн өөрчлөлт	(577,539,000)	(571,688,000)	299,509,000
		Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	92,974,324,000	78,539,186,008	108,972,079,592
1.1.	Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт				
	- Албан бичгээр хүргүүлж, МХБ болон компанийн цахим хуудсанд байршуулсан.				
1.2.	Аудитын тодорхойлох захидал /тодорхойлох захидлыг энэхүү зааварт дурдсан агуулгын хүрээнд боловсруулсан байх/				
	- Аудитын тодорхойлох захидлын агуулгыг хараат бус аудиторын тайлан, дүгнэлтэд тусгасан бөгөөд аудитын байгууллагад 2025 онд аудитын хөлсөнд 1,264,697 мянган төг, аудитын бус үйлчилгээний хөлсөнд 21,340 мянган төг төлсөн болно.				
2.	Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, удирдлагаас өгсөн үнэлгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч тайлбарласан тайлан, мэдээлэл				
2.1.	Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/	Харьцаанууд	2024	Дахин тайлагнасан 2024	2025
		Нийт ашгийн хувь	49%	42%	43%
		Үйл ажиллагааны ашгийн хувь	18%	21%	19%
		Цэвэр ашгийн хувь	15%	16%	16%
		Өөрийн хөрөнгийн өгөөж	25%	28%	25%
		Нэгж хувьцаанд ногдох ашиг	181.25	206.49	195.32
2.2.	Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт	Харьцаанууд	2024	Дахин тайлагнасан 2024	2025
		Эргэлтийн харьцаа	3.07	3.64	4.45
		Түргэн хөрвөх чадварын харьцаа	1.69	2.03	2.58
		Өр болон өөрийн хөрөнгийн харьцаа	0.36	0.27	0.34
2.3.	Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл	- 2025 онд инфляц болон гадаад валютын ханшийн нөлөөлөл харьцангуй тогтвортой байсан. - Согтууруулах ундааны зах зээлд хэрэглэгчдийн худалдан авалтын чиг хандлага импортын бүтээгдэхүүн рүү шилжиж буйтай холбогдон дотоодын өрсөлдөөн нэмэгдсээр байна. - Сүү, сүүн бүтээгдэхүүний зах зээлд эзлэх хувийг өсгөх зорилгоор нэмэлт санхүүжилт татан төвлөрүүлж, үйлдвэрлэл болон дэд бүтцийн хөрөнгө оруулалтуудыг шат дараатайгаар хэрэгжүүлж байна. - Бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, хэрэглэгчдийн хэрэгцээг илүү өргөн хүрээнд хангах зорилгоор сүү, сүүн бүтээгдэхүүний брэнд болон нэр төрлийг нэмэгдүүлэн, тасралтгүй хөгжүүлж ажилласан			

2.4.	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл /off balance/	- Балансын гадуурх ажил гүйлгээ байхгүй болно.						
2.5.	Тайлант хугацаанд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл;	<table><tr><th>Зээл</th><th>2025</th></tr><tr><td>Авсан зээл</td><td>127,911,028,000</td></tr><tr><td>Төлсөн зээл</td><td>28,588,613,000</td></tr></table>	Зээл	2025	Авсан зээл	127,911,028,000	Төлсөн зээл	28,588,613,000
Зээл	2025							
Авсан зээл	127,911,028,000							
Төлсөн зээл	28,588,613,000							
3.	Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/							
	Их хэмжээний хэлцэл: - Их хэмжээний хэлцэл тухайн тайлант жилд гараагүй. Сонирхлын зөрчилтэй хэлцэл: - Аудитын дэлгэрэнгүй тайлангийн тодруулга хэсэгт холбоотой талуудын ажил гүйлгээнээс гадна сонирхлын зөрчилтэй этгээдтэй хийсэн гүйлгээний жагсаалтыг тодруулсан болно. Үүнээс өөр гүйлгээ байхгүй болно.							
4.	Цалин урамшууллын мэдээлэл							
	ТУЗ-ийн цалин, урамшуулал Цалин урамшууллын бодлогод ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээ, олгох хэлбэр, давтамжийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэн баталж, гүйцэтгэлийг Компанийн жилийн тайланд тодорхой тусгахаар заасан. Сар бүр ТУЗ-ийн даргад 10 сая, ТУЗ-ийн гишүүдэд 6.5 сая төгрөгийн тогтмол цалин олгодог ба нэмэлт урамшуулал олгодоггүй. 2025 онд ТУЗ-ийн цалин, урамшууллын хэмжээнд өөрчлөлт ороогүй. Гүйцэтгэх удирдлагын цалин, урамшуулал Цалин урамшууллын бодлогод Гүйцэтгэх захирлын цалин, урамшуулал үндсэн цалин, урамшууллаас бүрдэж, ТУЗ-тэй байгуулсан гэрээгээр тодорхойлогдохоор заасан. Компанийн гүйцэтгэх удирдлагыг Гүйцэтгэх захирал (хувь хүн) хэрэгжүүлдэг. Гүйцэтгэх захирлыг сонгох, чөлөөлөх, бүрэн эрхийг тогтоох, түүнтэй байгуулах гэрээний нөхцөл, цалин, шагнал урамшуулал, хариуцлагын хэмжээг тогтоох нь ТУЗ-ийн бүрэн эрхэд хамаарна. АПУ ХК-ийн Гүйцэтгэх захирал нь Компанийн охин компаниуд болох АПУ Трейдинг ХХК, М Би Си Азия Пасифик ХХК, СББ Трейд ХХК, Спирт бал бурам ХХК, ӨМӨЗО-ны Эйпиу Трейд ХХК-ийн Гүйцэтгэх захирлаар давхар томилогдон ажилладаг. Гүйцэтгэх захиралд ТУЗ-тэй байгуулсан гэрээнд заасан үндсэн цалингаас гадна “борлуулалтын орлого”, “хүү, татварын өмнөх ашиг”, “зардлын хэмнэлт”, “хүн ба байгууллагын хөгжлийн төлөвлөгөөний гүйцэтгэл болон байгууллагын соёлыг сайжруулах ажлуудын үр дүн” гэсэн 4 үндсэн шалгуур үзүүлэлтийг ижил хувийн жинтэйгээр тооцож, урамшуулал олгодог. Компанийн ажилтны цалин, урамшуулал Цалин урамшууллын бодлогод Компанийн гүйцэтгэх удирдлагын багийн гишүүд болон нийт ажилтны цалин, урамшууллыг Гүйцэтгэх захирал тогтоодог.							
5.	Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл							
	АПУ Групп компанийн бүтэц АПУ групп компанийн бүтцэд “Эс Жи Пи И” ХХК шинээр нэмэгдсэн. ТУЗ-ийн 2025 оны 10 сарын 27-ны өдрийн 25/14 тоот тогтоолд үндэслэн АПУ Групп компани 2025 оны 11 сарын 12-ны өдөр “Эс жи пи и” ХХК-ийн 56.68%, (үүнд АПУ ХК дангаар 35.32%)-ийн хувьцаа эзэмшигчээр бүртгэгдсэн болно. Хувьцаа эзэмшигчдийн хурал АПУ ХК-ийн эрх барих дээд удирдлага нь хувьцаа эзэмшигчдийн хурал юм. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2025 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 14:00-15:10 цагийн хооронд цахим хэлбэрээр зохион байгуулагдаж, 88%-ийн ирцтэйгээр дараах хоёр асуудлыг хэлэлцэн шийдвэрлэв. Үүнд:							

1. АПУ ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан “2024 онд тавьсан зорилтуудаа биелүүлж амжилттай ажилласан” гэсэн дүгнэлтийг батлав.
2. ТУЗ-ийн цалин урамшууллыг өөрчлөлтгүй буюу ТУЗ-ийн дарга 10 сая, ТУЗ-ийн гишүүд 6.5 сая байхаар батлав.

Төлөөлөн удирдах зөвлөл

Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт ТУЗ компанийг удирддаг. ТУЗ нь Компанийн тухай хууль, Компанийн дүрэм, Компанийн дотоод журамд заасан АПУ ХК-ийн ТУЗ-ийн болон түүний охин, хараат компаниудын хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрх, үүргийг хэрэгжүүлдэг.

ТУЗ-ийн бүрэлдэхүүн

Хувьцаа эзэмшигчдийн 2024 оны ээлжит хурлаар 3 жилийн хугацаатай сонгосон ТУЗ-ийн бүрэлдэхүүнд өөрчлөлт ороогүй.

ТУЗ-ийн бүрэлдэхүүн

ТУЗ-ийн ердийн гишүүн бөгөөд ТУЗ-ийн дарга

ПҮРЭВИЙН БАТСАЙХАН

Инженер мэргэжилтэй

Шунхлай холдинг ХХК-ийн Ерөнхийлөгч

2002 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн дарга

Хувьцаа эзэмшил:

Хувь хүн: 96,300 ширхэг (0.01%)

Шунхлай холдинг ХХК: 602,651,260 ширхэг (56.63%)



ТУЗ-ийн ердийн гишүүн

БҮРЭНТОГТОХЫН БАТБАЯР

Эдийн засагч мэргэжилтэй

Шунхлай холдинг ХХК-ийн Гүйцэтгэх дэд ерөнхийлөгч

2013 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн

Хувьцаа эзэмшил:

Хувь хүн: 82,497 ширхэг (0.01%)

Шунхлай холдинг ХХК: 602,651,260 ширхэг (56.63%)



ТУЗ-ийн ердийн гишүүн

КЕННЕТ ЧУ

Нягтлан бодогч, менежмент мэргэжилтэй

Хайнекен Азиа Пасифик, Ази-Номхон далайн бүсийг хариуцсан Гүйцэтгэх захирал

2018 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн

Хувьцаа эзэмшил:

Хувь хүн: 0 ширхэг (0.00%)

Хайнекен Азиа Пасифик Пте Лтд: 266,091,981 ширхэг (25.00%)



ТУЗ-ийн ердийн гишүүн

СЭН И-ИН

Хуульч мэргэжилтэй.

Хайнекен Азиа Пасифик компанийн Ази-Номхон далайн бүсийн Хууль эрхзүй хариуцсан захирал

2020 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн

Хувьцаа эзэмшил:

Хувь хүн: 0 ширхэг (0.00%)

Хайнекен Азиа Пасифик Пте Лтд: 266,091,981 ширхэг (25.00%)



ТУЗ-ийн ердийн гишүүн

БАТСАЙХАНЫ ГАНТИГ

Бизнесийн удирдлага, менежмент мэргэжилтэй

Дижитал концепт ХХК-ийн Гүйцэтгэх захирал

2024 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн

Хувьцаа эзэмшил:

Хувь хүн: 1,000 ширхэг (0.00%)

Шунхлай холдинг ХХК: 602,651,260 ширхэг (56.63%)



ТУЗ-ийн ердийн гишүүн

БАЯРЦОГТЫН ГОМБО-ЭРДЭНЭ

Хэрэглээний математикч, эдийн засагч, санхүүч мэргэжилтэй

Шунхлай холдинг ХХК-ийн Бизнес хөгжил хариуцсан захирал

2024 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн

Хувьцаа эзэмшил:

Хувь хүн: 100 ширхэг (0.00%)

Шунхлай холдинг ХХК: 602,651,260 ширхэг (56.63%)



ТУЗ-ийн хараат бус гишүүн
ЁНДОН-ОЙДОВЫН ГЭРЭЛЧУЛУУН
 Эдийн засагч мэргэжилтэй
 Нээлттэй хот ТББ-ын үүсгэн байгуулагч
 2017 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн
 Хувьцаа эзэмшил: 0 ширхэг (0.00%)



ТУЗ-ийн хараат бус гишүүн
ОДОНЧИМЭДИЙН ОДБАЯР
 Багш, эрх зүйч мэргэжилтэй
 Ард даатгал ХК, Ард холдинг ХХК, Монгол шуудан ХК-уудын ТУЗ-ийн гишүүн
 2021 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн
 Хувьцаа эзэмшил: 0 ширхэг (0.00%)



ТУЗ-ийн хараат бус гишүүн
ЖИГЖИДИЙН ҮНЭНБАТ
 Эдийн засагч мэргэжилтэй
 2013 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн
 Хувьцаа эзэмшил: 0 ширхэг (0.00%)



ТУЗ-ийн үйл ажиллагааны тайлан

ТУЗ нь танхимаар, танхим-цахим хосолсон, эчнээ санал хураалтын хэлбэрээр нийт 10 удаа, дунджаар 100%-ийн ирцтэй хуралдаж, бүрэн эрхийнхээ хүрээнд нийт 45 тогтоол гаргав.

Хурлын				Баталсан тогтоолын тоо								
Д/д	Огноо	Ирц	Нийт	АПУ ХК	АПУ Дэйри ХХК	АПУ Трейдинг ХХК	М Би Си Азиа Пасифик ХХК	СББ Трейд ХХК	Спирт бал бурам ХХК	ОХУ-ын Гранд ХХК	ОХУ-ын Гранд Ист ХХК	БНХАУ ӨМӨЗО-ны Эйпиюу трейд ХХК
				ТУЗ-ийн хурал	Хувьцаа эзэмшигчдийн хурал							
1	2025.02.10	100%	11	2	2	1	1	1	1	1	1	1
2	2025.03.14	100%	1	1								
3	2025.04.16	100%	1	1								
4	2025.05.20	100%	4	3			1					
5	2025.06.26	100%	4	2	1		1					
6	2025.07.31	100%	2	2								
7	2025.09.19	100%	6	2		1	1	1	1			
8	2025.10.27	100%	10	2		2	2	2	2			
9	2025.11.27	100%	3	3								
10	2025.12.03	100%	3	3								
	Нийт	100%	45	21	3	4	6	4	4	1	1	1


Жилийн турш ТУЗ-ийн гишүүн бүр бүх хуралд 100%-ийн ирцтэй оролцлоо.

ТУЗ-ийн дэргэдэх хороод

Компанийн тухай хуулийн 81.2-т заасны дагуу ТУЗ-ийн дэргэд Аудитын, Нэр дэвшүүлэх, Цалин урамшууллын хороо ажилладаг бөгөөд хороодын гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь ТУЗ-ийн хараат бус гишүүн юм.

Тайлант хугацаанд ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүнд өөрчлөлт ороогүй бөгөөд хороод Компанийн тухай хууль, Компанийн дүрэм, хороодын журамд заасан эрх, үүргийг хэрэгжүүлэн ажиллав.

ТУЗ-ийн хороод	Аудитын хороо	Нэр дэвшүүлэх хороо	Цалин урамшууллын хороо
Хорооны дарга	Ж.Үнэнбат	О.Одбаяр	Ё.Гэрэлчулуун
Хорооны гишүүд	Сэн И-Ин О.Одбаяр	П.Батсайхан Ё.Гэрэлчулуун	Кеннет Чу Ж.Үнэнбат
Хуралдсан тоо	2	1	2
Ирц	100%	100%	100%
Хэлэлцэн шийдвэрлэсэн асуудал	- Компанийн 2024 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд хийсэн аудитын	- ТУЗ-ийн үйл ажиллагааны болон ТУЗ-ийн гишүүдийн	- ТУЗ-ийн цалин урамшууллыг өөрчлөлтгүйгээр тогтоож, хувьцаа

	дүгнэлт, тайлантай танилцаж, хүлээн авах - Групп компанийн хэмжээнд 2025 оны санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит хийх байгууллагыг сонгож, ТУЗ-д санал болгох үнэлгээний үр дүнг нэгтгэн, танилцах эзэмшигчдийн хуралд санал болгох - Групп компанийн түлхүүр ажилтнуудад хуримтлал үүсгэх гэрээ байгуулахыг ТУЗ-д санал болгох												
	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Тайлант хугацаанд ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар Базаррагчаагийн Сарантунгалаг ажиллаж, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь 2025 онд Компанийн ТУЗ-ийн ажлын албаны дарга бөгөөд Комплайнсын нэгжийн удирдлагын үүргийг гүйцэтгэж ажиллав. БАЗАРРАГЧААГИЙН САРАНТУНГАЛАГ Бизнесийн удирдлага мэргэжилтэй 2024 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Хувьцаа эзэмшил: 2,712 ширхэг (0.00%) 												
6.	Зах зээлийн эрсдэлийн мэдээлэл												
	Эрсдэлийн удирдлага Компанийн дотоод үйл ажиллагаанд эрсдэлийн удирдлагын программ хангамжийг ашиглан болзошгүй эрсдэлүүдийг бизнесийн үйл ажиллагаанд үзүүлэх нөлөөлөл болон илрэх магадлалаар нь үнэлэн тодорхойлж, богино болон урт хугацаанд эрсдэлүүдийг оновчтой удирдах шийдвэр гаргалтад ашиглаж байна. Мөн салбар болон компанийн үйл ажиллагаанд шууд болон шууд бусаар нөлөөлөх томоохон эрсдэлүүдээс ач холбогдлоороо хамгийн өндөрт эрэмбэлэгдсэн дараах дөрвөн үндсэн эрсдэлийг онцлон тодорхойлж ажиллалаа. Үүнд: - Түүхий эд, бараа материалын ханган нийлүүлэлт - Импортын бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт - Логистикийн үйл ажиллагаа - Эдийн засгийн нөхцөл байдал - Гадаад валютын ханшийн хөдөлгөөн - Инфляц - Хэрэглэгчийн худалдан авах чадамж - Эрчим хүчний хангамж ба тогтвортой байдал - Хэрэглээний хязгаарлалт - Эрчим хүч, дулааны үнийн өсөлт - Хөдөлмөрийн зах зээл - Ажиллах хүчний тогтвортой байдал - Мэргэшсэн ажиллах хүчний хомсдол												
7.	Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл /5 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдийн нэрс эзэмшлийн хувь, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо/												
	Нийт хувьцаа эзэмшигчдийн тоо¹  <table border="1"> <thead> <tr> <th>Он</th> <th>Хувьцаа эзэмшигчдийн тоо</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>2025 он</td> <td>34,918</td> </tr> <tr> <td>2024 он</td> <td>31,950</td> </tr> <tr> <td>2023 он</td> <td>20,556</td> </tr> <tr> <td>2022 он</td> <td>16,699</td> </tr> <tr> <td>2021 он</td> <td>12,149</td> </tr> </tbody> </table> АПУ компани 2025 оны эцэст 34,918 хувьцаа эзэмшигчтэйгээр хувьцаат компаниуд дунд дөрөвдүгээрт эрэмбэлэгдэж байна.	Он	Хувьцаа эзэмшигчдийн тоо	2025 он	34,918	2024 он	31,950	2023 он	20,556	2022 он	16,699	2021 он	12,149
Он	Хувьцаа эзэмшигчдийн тоо												
2025 он	34,918												
2024 он	31,950												
2023 он	20,556												
2022 он	16,699												
2021 он	12,149												

¹ ҮЦТХТ ХХК-аас гаргасан 2025.12.31-ний өдрийн байдлаарх үнэт цаасны төвлөрлийн судалгааны мэдээлэл

Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид ²					
		2024 оны эцэс		2025 оны эцэс	
Д/д	Хувьцаа эзэмшигч	Хувьцааны тоо ширхэг	Нийт гаргасан хувьцаанд эзлэх хувь	Хувьцааны тоо ширхэг	Нийт гаргасан хувьцаанд эзлэх хувь
1	Шунхлай Холдинг ХХК	602,651,260	56.63	602,651,260	56.63
2	Хайнекен Азия Пасифик Пте Лтд	266,091,981	25.00	266,091,981	25.00
3	Степпе Бэвэриж КФТ	59,351,609	5.58	58,829,058	5.53
4	Бусад	136,086,703	12.79	136,609,254	12.84
Өмнөх онтой харьцуулбал нөлөө бүхий хувьцаа эзэмшигч Степпе Бэвэриж КФТ-ийн эзэмшлийн хувьцаа 522,551 ширхэг буюу 0.05%-аар буурч олон нийтийн эзэмшилд шилжжээ.					
8.	Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойш дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл				
	Тайлант хугацаанд олон нийтэд санал болгон хувьцаа гаргаагүй.				
9.	Ногдол ашгийн мэдээлэл				
Ногдол ашгийн бодлого Ногдол ашгийн бодлогоор Компани дор дурдсан нөхцөлд цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилна: ✓ Ногдол ашиг төлсний дараа компани төлбөрийн чадвартай байх, ✓ Ногдол ашиг төлсний дараа Компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг, түүний татан буулгалтын үнэ, хуульд заасан өөрийн хөрөнгийн доод хэмжээний нийлбэрээс их байх, ✓ Компани эргүүлэн авах үүрэгтэй үнэт цаасаа бүрэн авсан байх. Ногдол ашиг хуваарилах эсэх шийдвэрийг ТУЗ гаргах ба санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор, хагас жилээр ногдол ашиг хуваарилах тохиолдолд хагас жилийн санхүүгийн тайлан гарснаас хойш 30 хоногийн дотор хэлэлцэн шийдвэрлэнэ. ТУЗ нь ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэвэл энэ тухайгаа хувьцаа эзэмшигчдийн хуралд заавал тайлагнана. Ногдол ашиг хуваарилалт АПУ ХК-ийн ТУЗ-өөс 2025 оны нийлбэр дүнгээр компанийн хувьцаа эзэмшигчдийн нэгж хувьцаанд нийт 130 төгрөгийн ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн болно.					
	Тайлант хугацаа	ТУЗ-өөс ногдол ашиг зарласан өдөр	Нэгж хувьцаанд зарласан ногдол ашиг	Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гарах бүртгэлийн өдөр	Ногдол ашиг төлөхөөр тогтоосон сүүлийн өдөр
	2025 оны I хагас жил	2025.07.31	65 төг	2025.08.18	2026.02.10
	2025 оны II хагас жил	2026.02.12	65 төг	2026.04.02	2026.08.19
	НИЙТ		130 төг		2026.04.30-ны дотор төлнө.
Ногдол ашгийн төлбөрийг нийт хувьцааны таваас доош хувийг эзэмшигчдэд “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-аар зуучлуулан, таваас дээш хувийг эзэмшигчдэд компаниас шууд төлөх замаар мөнгөн хэлбэрээр олгож байна.					
10.	Үнэт цаас гаргагчаас тайлант хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлын тайлангийн мэдээлэл				
	Компани БОНЗ, тогтвортой хөгжлийн тайлангаар тусад нь тайлагнадаг.				

² ҮЦТХТ ХХК-аас гаргасан 2025.12.31-ний өдрийн байдлаарх үнэт цаас эзэмшигчдийн судалгааны мэдээлэл

Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Цэвээнжавын Эрдэнэбилэг
Албан тушаал: “АПУ” ХК-ийн гүйцэтгэх захирал

Гарын үсэг:

(Тамга/тэмдэг)



Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Базаррагчаагийн Сарантунгалаг
Албан тушаал: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

Гарын үсэг:

Sarc